



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/238-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363047	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
--	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11-12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12-13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13-14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14-15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	15-16
3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16-17
4. Аудитын илрүүлэлт	17-18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НА	Нотлох ажил
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.17 № СЭА-2022/238-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Б. ГАНХУЯГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	166,861,444.79	176,941,605.29
35	БАРАА МАТЕРИАЛ	166,861,444.79	176,941,605.29
35100	Түүхий эд материал	88,592,005.39	90,574,748.89
35110	Тусгай зориулалттай материал	82,267,005.39	84,249,748.89
35130	Эм боох материал	6,325,000.00	6,325,000.00
35400	Хангамжийн материал	72,252,156.40	79,732,151.40
35410	Бичиг хэргийн материал	1,769,700.00	3,135,290.00
35420	Аж ахуйн материал	45,457,018.30	72,367,087.30
35440	Түлш, шатах тослох материал	9,502,871.60	1,529,902.60
35460	Хүнсний материал	297,057.50	7.50
35470	Бусад хангамжийн материал	15,225,509.00	2,699,864.00
35600	Мал амьтад	6,017,283.00	6,634,705.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,018,442,608.91	1,915,251,347.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,018,442,608.91	1,915,251,347.25
39200	Биет хөрөнгө	1,814,207,508.91	1,691,792,247.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,359,309,136.30	1,359,309,136.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-114,425,140.06	-192,114,935.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,734,040.24	245,655,766.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,392,681.10	-96,559,539.14
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	595,000,121.11	562,670,753.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	-238,147,672.56	-303,927,380.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,924,957.66	75,969,642.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,782,052.68	-20,197,995.96
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	60,986,800.00	60,986,800.00
39300	Биет бус хөрөнгө	204,235,100.00	223,459,100.00
39301	Програм хангамж	1,225,000.00	1,225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,225,000.00	-1,225,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	204,235,100.00	223,459,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,185,304,053.70	2,092,192,952.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,185,304,053.70	2,092,192,952.54
51	Засгийн газрын хувь оролцоо	2,185,304,053.70	2,092,192,952.54
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,207,738,655.49	1,226,962,655.49
51200	Хуримтлагдсан үр дүн	132,578,791.47	20,243,690.31
51210	Өмнөх үеийн үр дүн	-170,375,494.76	132,578,791.47
51220	Тайлант үеийн үр дүн	302,954,286.23	-112,335,101.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	844,986,606.74	844,986,606.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,185,304,053.70	2,092,192,952.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,154,950,627.01	2,847,835,204.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	647,880,327.01	207,804,978.37
120	Нийтлэг татварын бус орлого	647,880,327.01	207,804,978.37

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	130,928,890.00	49,483,023.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,068,250.00	18,141,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	118,860,640.00	31,341,823.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	367,231,551.61	97,732,414.37
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	149,719,885.40	60,589,541.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,507,070,300.00	2,640,030,226.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,470,566,800.00	2,591,043,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,470,566,800.00	2,591,043,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,503,500.00	48,986,726.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	27,436,726.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,503,500.00	21,550,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,851,996,340.78	2,952,827,305.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,851,996,340.78	2,952,827,305.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,836,101,490.78	2,943,032,605.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,096,852,000.00	2,218,494,500.00
210101	Үндсэн цалин	1,068,582,402.00	1,211,823,629.00
210102	Нэмэгдэл	1,028,269,598.00	1,006,670,871.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,274,000.00	47,719,500.00
210201	Тэтгэврийн даатгал	378,000.00	567,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	44,400.00	66,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,600.00	53,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,800.00	13,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,807,200.00	47,019,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,383,400.00	91,805,000.00
210301	Гэрэл, цахилгаан	12,144,521.00	19,086,180.00
210302	Түлш, халаалт	62,671,700.00	62,783,862.00
210303	Цэвэр, бохир ус	7,567,179.00	9,934,958.00
2104	Хангамж, бараа материалын зардал	254,193,200.00	204,177,282.00
210401	Бичиг хэрэг	16,354,008.00	14,829,400.00
210402	Тээвэр, шатахуун	210,777,100.00	157,254,402.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,194,000.00	16,290,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	156,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,088,092.00	10,076,084.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,571,236.00
2105	Нормативт зардал	34,304,905.34	36,324,430.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	411,717.00	1,046,180.00
210502	Хоол, хүнс	33,178,188.34	35,278,250.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,141,911.88	51,299,427.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,350,711.88	22,827,200.00
210604	Урсгал засвар	32,791,200.00	28,472,227.00
2107	Томилолт, зочны зардал	12,063,000.00	30,039,200.00
210702	Дотоод албан томилолт	12,063,000.00	30,039,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,506,161.00	15,063,645.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.00	950,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	156,161.00	13,713,645.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,382,912.56	248,109,621.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,171,732.00	6,697,326.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,443,590.00	1,246,619.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	207,767,590.56	240,165,676.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,894,850.00	9,794,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,905,000.00	5,460,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,905,000.00	4,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,989,850.00	4,334,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,989,850.00	4,334,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	302,954,286.23	-104,992,101.33
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	7,342,999.83
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	7,342,999.83
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	302,954,286.23	-112,335,101.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,519,138,550.00	2,658,171,426.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,068,250.00	18,141,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,068,250.00	18,141,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,068,250.00	18,141,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,068,250.00	18,141,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,507,070,300.00	2,640,030,226.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,470,566,800.00	2,591,043,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,470,566,800.00	2,591,043,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,503,500.00	48,986,726.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	27,436,726.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,503,500.00	21,550,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,519,138,550.00	2,657,171,426.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,519,138,550.00	2,657,171,426.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,503,243,700.00	2,647,376,726.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,096,852,000.00	2,218,494,500.00
210101	Үндсэн цалин	1,358,064,100.00	1,297,372,200.00
210102	Нэмэгдэл	738,787,900.00	921,122,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,274,000.00	47,719,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	50,274,000.00	47,719,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,383,400.00	91,805,000.00
210301	Гэрэл, цахилгаан	12,144,521.00	19,086,180.00
210302	Түлш, халаалт	62,671,700.00	62,783,862.00
210303	Цэвэр, бохир ус	7,567,179.00	9,934,958.00
2104	Хангамж, бараа материалын зардал	160,912,800.00	160,412,800.00
210401	Бичиг хэрэг	16,060,000.00	13,838,540.00
210402	Тээвэр, шатахуун	124,578,800.00	126,989,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,194,000.00	15,669,160.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	156,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,300,000.00	3,639,900.00
2105	Нормативт зардал	27,073,500.00	24,455,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	25,373,500.00	22,655,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,950,000.00	34,950,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	35,950,000.00	30,950,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,063,000.00	17,703,200.00
210702	Дотоод албан томилолт	12,063,000.00	17,703,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,350,000.00	1,350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.00	950,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,385,000.00	50,486,726.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,985,000.00	47,986,726.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400,000.00	2,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,894,850.00	9,794,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,905,000.00	5,460,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,905,000.00	4,960,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,989,850.00	4,334,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,989,850.00	4,334,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	1,000,000.00

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-1,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,149,851,555.49	844,986,606.74	-170,375,494.76	1,824,462,667.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,149,851,555.49	844,986,606.74	-170,375,494.76	1,824,462,667.47
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	57,887,100.00	0.00	0.00	57,887,100.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	302,954,286.23	302,954,286.23
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,207,738,655.49	844,986,606.74	132,578,791.47	2,185,304,053.70
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,207,738,655.49	844,986,606.74	132,578,791.47	2,185,304,053.70
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,207,738,655.49	844,986,606.74	132,578,791.47	2,185,304,053.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	19,224,000.00	0.00	0.00	19,224,000.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-112,335,101.16	-112,335,101.16
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,226,962,655.49	844,986,606.74	20,243,690.31	2,092,192,952.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,606,043,500.00	2,604,850,000.00	1,193,500.00	99.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,606,043,500.00	2,604,850,000.00	1,193,500.00	99.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,600,583,500.00	2,599,390,000.00	1,193,500.00	99.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,218,494,500.00	2,218,494,500.00	0.00	100.00

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	1,297,372,200.00	1,297,372,200.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	921,122,300.00	921,122,300.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,719,500.00	47,719,500.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,719,500.00	47,719,500.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,805,000.00	91,805,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	13,670,400.00	19,086,180.00	5,415,780.00	139.62
210302	Түлш, халаалт	70,171,700.00	62,783,862.00	7,387,838.00	89.47
210303	Цэвэр, бохир ус	7,962,900.00	9,934,958.00	1,972,058.00	124.77
2104	Хангамж, бараа материалын зардал	160,412,800.00	160,412,800.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	14,060,000.00	13,838,540.00	221,460.00	98.42
210402	Тээвэр, шатахуун	127,078,800.00	126,989,200.00	89,600.00	99.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,194,000.00	15,669,160.00	-475,160.00	103.13
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	156,000.00	504,000.00	23.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	3,639,900.00	-339,900.00	110.30
2105	Нормативт зардал	24,455,000.00	24,455,000.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	22,655,000.00	22,655,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,950,000.00	34,950,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	30,950,000.00	30,950,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	18,063,000.00	17,703,200.00	359,800.00	98.01
210702	Дотоод албан томилолт	18,063,000.00	17,703,200.00	359,800.00	98.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,183,700.00	1,350,000.00	833,700.00	61.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	833,700.00	0.00	833,700.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	950,000.00	950,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000.00	400,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,460,000.00	5,460,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,460,000.00	5,460,000.00	0.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,960,000.00	4,960,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,606,043,500.00	2,609,184,700.00	3,141,200.00	100.12
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,591,043,500.00	2,591,043,500.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,591,043,500.00	2,591,043,500.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	18,141,200.00	3,141,200.00	120.94
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	18,141,200.00	3,141,200.00	120.94
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	150.00	144.00	6.00	96.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	145.00	139.00	6.00	95.86
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	150.00	144.00	6.00	96.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	146.00	140.00	6.00	95.89
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,986,726.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,986,726.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,986,726.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,986,726.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,986,726.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,986,726.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,986,726.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,436,726.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,550,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын /цаашид аймгийн Цагдаагийн газар гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, цалингийн тооцоолол, суутгалыг үнэн зөв хийж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 42/1-346 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус газар нь 2021 онд “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах” гэсэн зорилго тавин ажилласан байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Нийгмийн хэв журам сахиулах;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;
- Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн тусгайлсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,851,996.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 42,779.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 32,084.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93,111.1 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	166,861.40	176,941.60	10,080.20
Үндсэн хөрөнгө	2,018,442.60	1,915,251.30	-103,191.30
Нийт хөрөнгө	2,185,304.00	2,092,192.90	-93,111.10
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,185,304.00	2,092,192.90	-93,111.10
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,185,304.00	2,092,192.90	-93,111.10

Бараа материалын дансны үлдэгдэл 176,941.6 мянган төгрөг болж 10,080.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 209,069.6 мянган төгрөгийн материал худалдан авсан, ЦЕГ-аас 54,116.5 мянган төгрөгийн, Сүхбаатар сумын ЗДТГ болон Азийн хөгжлийн банк хамтарсан төслийн хүрээнд гэрч хохирогчийг хамгаалах байрны тохижилтод 17,266.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 259,667.7 мянган төгрөгийн материал зарцуулан, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 10,704.4 мянган төгрөгийн бараа материал акталсан зэргээс шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд он дамжсан, ашиглалтгүй хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,529,276.2 мянган төгрөг болж 50,861.1 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Засаг даргын 2021 оны А/37 дугаар захирамжаар өгсөн санхүүжилтээр 1,000.0 мянган төгрөгийн цахим хурлын төхөөрөмж худалдан авсан, ЦЕГ-аас 61,444.9 мянган төгрөгийн, Хууль зүйн яам болон Азийн хөгжлийн банк хамтарсан төслийн хүрээнд гэрч хохирогчийг хамгаалах байрны тохижилтод 36,287.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан болон өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 26,361.0 мянган төгрөгөөр, Шаамар, Хушаат сумын Цагдаагийн кабоны газрыг 19,224.0

мянган төгрөгөөр үнэлж орлогод авсан болон аймгийн ИТХТ-ийн 43 дугаар тогтоолоор 28,580.7 мянган төгрөгийн хөрөнгө акталсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,092,192.9 мянган төгрөг болж 93,111.1 мянган төгрөгөөр буурсан нь засгийн газрын сан 12,432.3 мянган төгрөгөөр өсөж, хуримтлагдсан үр дүн 105,543.4 мянган төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ.

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 307,115.4 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 307,115.4 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 100,830.9 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн нь тайлант онд нийт албан хаагчдад төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл цалин олгож эхэлснээс цалингийн зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,781,913.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 323,202.7 мянган төгрөгөөр бууруулж, 2,458,710.6 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Тайлант онд батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж, 2021 оны 12-р сард 147,332.9 мянган төгрөгөөр өсгөн, **2,606,043.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 141,944.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 5,388.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,606,043.5 мянган төгрөгийн төсөв баталж, 2,591,043.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,591,043.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 18,141.2 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэн **2,604,850.0** мянган төгрөгийг зарцуулж, тайлант оны эцэст 4,334.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 3,141.2 мянган төгрөг нь үндсэн үйл ажиллагааны давсан орлого, 833.7 мянган төгрөг нь бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, 359.8 мянган төгрөг нь албан томилолтын зардлын хэмнэлт байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 27,436.7 мянган төгрөг, аймгийн БОАЖГ-аас 20,000.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас 1,550.0 мянган төгрөг зэрэг нийт 48,986.7 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Үүнээс онлайн хурлын тоног төхөөрөмж 1,000.0 мянган төгрөг, эрүүлжүүлэх байранд камер 1,550.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 8,336.7 мянган төгрөг, хоол хүнсэнд 5,840.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 32,260.0 мянган төгрөг, нийт 48,986.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 ЦЕГ-аас “Киа моторс-Монгол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2021 онд үйлдвэрлэж, монголд орж ирсэн KIA RIO суудлын автомашиныг тус газарт 2021 оны 8 дугаар сард хүлээлгэн өгсөн бөгөөд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас “ Автомашин нийлүүлэх санхүүгийн түрээсийн гэрээ”-ний дагуу төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэл автомашины өмчлөл нь нийлүүлэгч байгууллагад байх тул тээврийн хэрэгслийн ашиглалтад байнгын хяналт тавьж, тухай бүр үзлэг оношилгоонд хамруулж, албаны бэлэн байдлыг ханган, ашиглах чиглэл өгснийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Цагдаагийн газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,653.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс цалингийн тооцооллыг зөв хийж, бүртгэлийг стандартын дагуу гүйцэтгэх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Тайлант онд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын 2021 оны 05 сарын 12-ны өдрийн 15 дугаар мэдэгдлээр тус хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 1.5 сарын үндсэн цалин буюу 2,920.6 мянган төгрөгийн урамшуулал олгох шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгох шийдвэр гаргахгүй байх, улирлын үр дүнгийн урамшууллыг албан тушаалын сарын цалингийн 40 хувиас хэтрүүлэн олгохгүй байх нь зүйтэй юм.

3.11.2 ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын даргын тушаалаар тус газарт ажилладаггүй боловч Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан 2 боть түүхэн бүтээл туурвиж буй гэх Н.Алтантөгсийг эргүүлийн цагдаагийн орон тоон дээр цалинжуулж, нийт 9,980.5 мянган төгрөгийн цалин тооцож, олгосон байна.

Цаашид тус байгууллагад ажил эрхэлдэггүй хүнд цалин олгож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг таслан зогсоох нь зүйтэй юм.

3.11.3 ЦЕГ-аас 2021 оны 12 сард балансас балансд шилжиж ирсэн 51,621.7 мянган төгрөгийн 5 суудлын автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь байгууллагын эзэмшилд бүртгэгдээгүй байгаа нь Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 3.2-д "Өмчлөгч нь энэ журмын 3.1-д заасан шилжилт, хөдөлгөөнийг 7 хоногийн дотор хийлгэх үүрэгтэй", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 13 (а)-д тодорхойлсон заалттай нийцээгүй ба "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд 2022 оны эхний хагас жилд багтаан тээврийн хэрэгслийн гэрчилгээг, байгууллагын нэр дээр гаргуулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,543.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 3 зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 8,900.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт: Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой

байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах .

2.2.1 Илрүүлэлт: Ажлын үр дүнгээр сахилгын шийтгэл оногдуулж, 26 алба хаагчийн цалин хөлсийг 7,643.6 мянган төгрөгөөр бууруулахдаа цалингийн цэсийн нэмэгдэл талд хасах утгаар оруулж цалингийн тооцоолсон өглөгийг бууруулан, цалингийн зардлыг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

2.2.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын ажиллагчидтай холбогдсон зардлын бүртгэлийн 3.6 дахь “Тайлангийн хугацааны цалингийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ, 3.6.(б) дэх “Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ. Дт.өглөг-Цалингийн тооцооны Кт.Бусад өглөг-ажиллагчийн төлөх бусад суутган төлбөр” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчсөн тул цалингийн суутгалыг зөв хийж, бүртгэлийг стандартын дагуу гүйцэтгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Цагдаагийн газар	3	16,543.6	-	-	-	-	-	-	3	16,543.6